

**2019 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА
ХЭМЖЭЭ**

НИЙТИЙН БИЕЙН ТАМИРЫН АРГА ХЭМЖЭЭ:

- 2019 оны эхний хагас жилд Нийтийн биеийн тамирын 21 арга хэмжээг зохион байгуулж 399 байгууллагын 15149 иргэнийг хамруулан ажилласан.

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН “БАГШ – 2019” СПОРТЫН ДОЛООН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, багш нарын оюуны алжаал ядаргааг тайлах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, спортын ур чадварыг дээшлүүлэх, Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдыг сонгон шалгаруулахад оршино.

Нийслэлийн баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын аварга шалгаруулах “Багш - 2019” тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2018 оны 1-р сарын 09 ны өдөр 33-р дугаар сургуулийн спорт зааланд амжилттай боллоо.

Үндэсний бөх 01-р сарын 07 ны өдөр Шавь цогцолбор сургууль, Шатар 01-р сарын 08 ны өдөр Баянзүрх цогцолбор сургууль, Олс таталт 01-р сарын 11 ны өдөр Амгалан цогцолбор сургуульд, Сагсан бөмбөгийн тэмцээн 01-р сарын 09-10 ны өдөр 33, 14, 84-р сургуульд, Ширээний теннис 01-р сарын 08 ны өдөр 97-р сургуульд, Усан сэлэтийн тэмцээн 01-р сарын 11 ны өдөр 33-р сургуульд, Волейбол 01-р сарын 14-15 ны өдөрүүдэд 33, 84, 14-р сургуулиуд дээр тус тус амжилттай зохион байгуулагдаж өндөрлөө. Тэмцээнд нийт 30 сургуулийн, 204 багийн эрэгтэй 561, эмэгтэй 562 нийт 1123 багш ажилчид оролцлоо.

Мөн Багш-2019 тэмцээний шилдэгүүдээ шалгарууллаа. Үндэсний бөхийн Уран барилдаанчаар Амгалан цогцолбор сургуулийн О.Хаш-эрдэнэ, Волейболын Шилдэг эрэгтэй тоглогч 84-р сургуулийн И.Тамир, Шилдэг эмэгтэй тоглогч У.Онон, Сагсан бөмбөгийн Шилдэг эрэгтэй тоглогч Шинэ Монгол сургуулийн Жүгдэрнамжил, Шилдэг эмэгтэй тоглогч 33-р сургуулийн Д.Отгонзаяа нар тус тус шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 200 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН НЭРЭМЖИТ
XVII ЖАРНЫ “УРВУУЛАГЧ” ХЭМЭЭХ ШОРООН ГАХАЙ ЖИЛИЙН
САР ШИНИЙН БАЯРТ ЗОРИУЛСАН “ЭНЭ БӨХ ХЭНИЙ БӨХ ВЭ?”
БӨХИЙН БАРИЛДААН

Баянзүрх дүүргийн 200 дугаар цэцэрлэгийн нэрэмжит XVII жарны “УРВУУЛАГЧ” хэмээх шороон гахай жилийн сар шинийн баярт зориулсан “ЭНЭ БӨХ ХЭНИЙ БӨХ ВЭ?” Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн насны хүүхдүүдийн үндэсний бөхийн барилдаан 01-р сарын 26 нд Алдар спорт хорооны зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд Нийт 26 цэцэрлэгийн 88 тамирчин оролцлоо.

- 1.Түрүү бөхөөр 129-р цэцэрлэгийн А.Ананд - Өргөмжлөл алтан медаль
- 2.Үзүүр бөхөөр 200-р цэцэрлэгийн Э.Намсрай - Өргөмжлөл мөнгөн медаль
- 3.Шөвгийн дөрөвт 32 –р цэцэрлэгийн Н.Түвшинсайхан - Өргөмжлөл хүрэл медаль
- 4.Шөвгийн дөрөвт 212 –р цэцэрлэгийн А.Мөнхсайхан Өргөмжлөл хүрэл медаль
- 5.Тусгай байрт 20-р цэцэрлэгийн Б.Мөнхамьдрал –Өргөмжлөл хүрэл медаль
- 6.Тусгай байрт 169-р цэцэрлэгийн Б.Даваажаргал –Өргөмжлөл хүрэл медаль
- 7.Уран гараа дэвээ, шаваа бөхөөр 200-р цэцэрлэгийн О.Баярбилэг
- 8.Уран гараа дэвээ, шаваа бөхөөр 128-р цэцэрлэгийн М.Ирмүүн
- 9.Уран барилдаант бөхөөр 200-р цэцэрлэгийн Н.Батирээдүй
- 10.Уран барилдаант бөхөөр 129-р цэцэрлэгийн А.Ананд нар шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХОНХОТ БӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН

Дүүргийн хүн амын эрүүл мэндийг бэхжүүлж хамгаалах, нийтийн биеийн тамир спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах ажлын хүрээнд хараагүй иргэдийн дунд хонхтой бөмбөгийн тэмцээнийг жил бүр явуулж тэднийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, сэтгэл санаа бие бялдарыг нь сэргээн баг тамирчдын ур чадвар туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор хонхтой бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



Хонхтой бөмбөгийн тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 05-06-ны өдөр Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны зааланд амжилттай зохион байгуулагдаж

өндөрлөлөө. Тэмцээнд эмэгтэй эрэгтэй 10 багийн 50 гаруй тамирчид оролцлоо. Тэмцээний ерөнхий шүүгчээр БЗД-ийн Биеийн тамир спорт хорооны мэргэжилтэн С.Сувд, талбайн шүүгчээр Хонхтой бөмбөгийн холбооны нарийн бичгийн дарга П.Туул, Н.Анхбаяр, Б.Ганбат нарийн бичиг шүүгч О.Цэвэлмаа, Мөнхдэлгэр шугамын шүүгчээр Ж.Лхагва-Эрдэнэ, Сүхбаатар, Б.Гантулга, Ц.Уранчимэг, нар шүүн явууллаа.

Тэмцээний эхний 3 байр:

Эрэгтэй	нэгдүгээр байр хоёрдугаар байр гуравдугаар байр	МСҮТөв Баянзүрх дүүрэг Холбоо
Эмэгтэй	нэгдүгээр байр хоёрдугаар байр гуравдугаар байр	Баянзүрх дүүрэг 116-р баг МСҮТөв тус тус эзэлж алт, мөнгө, хүрэл

медалийн эзэд болж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.

БИЕ БЯЛДАРЫН ХӨГЖИЛТ ЧИЙРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 053 дугаар зарлигийн дагуу Баянзүрх дүүргийн ажилтан, албан хаагчид, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш ажилтан, сурагч хүүхдүүдээс “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг 2019 оны 4 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 30-ны өдрийг дуустал амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагчдын сорилыг 9 сард дүүргийн Засаг даргын захирамж гаргуулан авахаар болсон.

Одоогийн байдлаар дүүргийн хэмжээнд 3-5 насны 346, 6-8 насны 1241, 9-11 насны 1325, 12-17 насны 2930, 15-64 насны 349 хүн нийтдээ 6191 хүний бие бялдарын сорилыг авч үнэлэн онлайн бүртгэлээр шивж оруулаад байна.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДЫН “УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИК”-ИЙН ТЭМЦЭЭН



Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастикийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04 сарын 12-ны өдөр Шавь цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө тэмцээнд 15 сургуулийн 24 багийн 447 тамирчин, багш дасгалжуулагч нар оролцлоо.

Тэмцээний нээлтэнд Биеийн тамир спорт хорооны дарга МУГДасгалжуулагч С.Эрдэнэбат оролцож буй баг тамирчдад баяр хүргэж амжилт хүслээ.

Тэмцээний ерөнхий шүүгчээр гимнастикийн спортын мастер, улсын шүүгч Лхамсүрэн, гимнастикийн ОУХМастер, улсын шүүгч Энхтуяа, гимнастикийн ОУХМастер, улсын шүүгч Норолхоо, хөгжмийн шүүгчээр Ү.Болортуяа нар шүүн явууллаа.

Багийн дүнгээр:

1-р байрт Б.Уртнасан дасгалжуулагчтай 84-р сургууль

2-р байрт Гантогтох дасгалжуулагчтай Баянзүрх цогцолбор сургууль

3-р байрт Ш.Дүүргиймаа дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль тус тус байр эзэлж өргөмжлөл медаль мөнгөн шагналаар шагнаж урамжууллаа.

ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДҮҮДИЙН “УРАН ХӨДӨЛГӨӨНТ ГИМНАСТИК”-ИЙН ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04 сарын 18-ны өдөр Монгол бөхийн өргөөнд амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнд 17 цэцэрлэгийн 510 тамирчин, 68 багш, дасгалжуулагч 1000 гаруй хөгжөөнт дэмжигчид оролцлоо.

Нээлтэнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга С.Эрдэнэбат, Баянзүрх дүүргийн Боловсролын хэлтсийн дарга М.Цогзолмаа нар бяцхан тамирчдад баяр хүргэж амжилт хүсэн нээж үг хэллээ.



Тэмцээний ерөнхий шүүгчээр Биеийн тамир спортын хорооны мэргэжилтэн С.Сувд, шүүгчээр гимнастикийн спортын олон улсын хэмжээний мастер улсын шүүгч Д.Норолхоо, гимнастикийн спортын мастер улсын шүүгч Чанцалдулам, гимнастикийн спортын олон улсын хэмжээний мастер улсын шүүгч Энхтуяа, гимнастикийн спортын олон улсын хэмжээний мастер улсын шүүгч С.Тунгалаг, хөгжмийн шүүгчээр С.Энхбаяр, хөтлөгчөөр Д.Амгаланбаатар, Биеийн тамир, спортын хорооны мэргэжилтэн О.Түмэнжаргал, Б.Мөнхзаяа нар шүүн явууллаа.

Тэмцээний 1-р байр Х.Чимэдцэрэн эрхлэгчтэй 147-р цэцэрлэг

2-р байр Б.Эрдэнэчимэг эрхлэгчтэй 136-р цэцэрлэг

3-р байр Д.Рагчаасүрэн эрхлэгчтэй 61-р цэцэрлэг тус тус байр эзэллээ. Эхний 3 байранд шалгарсан цэцэрлэг Нийслэлийн Уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.

ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДҮҮДИЙН “100-Н БУУДАЛТ ДААМ”-НЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Монгол улсын гавьяат тамирчин Д.Эрдэнэбилэгийн нэрэмжит, Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохиогдсон 100-н буудалт даамны аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

100-н буудалт даамны тэмцээнд 24 цэцэрлэгийн 70 тамирчид оюун ухаанаа сорин амжилттай оролцлоо. Тэмцээн 5 нас, 6 насанд охид, хөвгүүд гэсэн 2 насны 4 ангилалд оюун ухаан, ур чадвараа сорилоо.

Багийн нийлбэр дүнгээр: 1-р байр 128-р цэцэрлэг
2-р байр 147-р цэцэрлэг
3-р байр 146-р цэцэрлэгүүд шалгарч өргөмжлөл,
мөнгөн шагналаар шагнууллаа.



“GUIDE” СНУКЕР БИЛЛИАРДЫН 2019 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Иргэдийг нийтийн биеийн тамир спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах тэднийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, сэтгэл санаа бие бялдарыг нь сэргээн баг тамирчдын ур чадвар туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор снукер биллиардын тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.



Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хороотой хамтран зохион байгуулсан GUIDE снукер биллиардын 2019 оны аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 10 дугаар сарын 26-ны өдөр GUIDE снукер биллиардын клубт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 10 багийн 20 тамирчин 2 зоонд хуваагдан өрсөлдсөн бөгөөд эхний 3 байранд шалгарсан баг тамирчдыг өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

- 1-р байр Нямжав ахлагчтай баг
- 2-р байр Эрдэнэбат ахлагчтай баг
- 3-р байр Дамдин ахлагчтай баг

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН САНХҮҮЧДИЙН СПОРТЫН ДӨРВӨН ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН

Санхүүгийн алба үүсэн байгуулагдсаны 108 жилийн ойн хүрээнд Баянзүрх дүүрэгт жил бүр уламжлал болгон зохион явуулдаг санхүүчдийн тэмцээн 2019 оны 11-р сарын 16-нд 14 дүгээр сургуулийн спорт зааланд амжилттай болж өндөрлөлөө.

Тэмцээнд Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын 9-н багийн 200 гаруй санхүүгийн ажилтан албан хаагчид оролцож спортын 4-н төрөлд /сагсан бөмбөг, волейбол, дартс, ширээний теннис/ хурд, хүч, авхаалж самбаа сорин өрсөлдлөө.

Тэмцээний нээлтэнд Эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч С.Гантулга, Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч Д.Уламбаяр, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Өсөхбаяр ирж тэмцээнд оролцогчдод амжилт хүсч баяр хүргэлээ.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН “ХАРИУ НЭХЭЭГҮЙ ТУС” ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан “Хариу нэхээгүй тус” сарын аяныг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг энэхүү ажлын хүрээнд дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд хөгжилтэй буухиа тэмцээнийг 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 55 дугаар дунд сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгууллаа.



Хариу нэхээгүй тус тэмцээний нээлтэнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны дарга С.Эрдэнэбат оролцож буй баг тамирчдад амжилт хүсч, баяр хүргэлээ. Тэмцээнд 13 багийн 90 гаруй хүүхдүүд оролцсон.

Тэмцээнд оролцож буй хүүхдүүдэд мэндчилгээ дэвшүүлж 55 дугаар сургуулийн сурагч ая дууны мэндчилгээ дэвшүүлж, Сүлд Тв ирж бичлэг хийн ярилцлага авлаа.

Тэмцээний 1-р байр Урангоо багштай 36 баг

2-р байр Гончигдорж багштай 1д баг

3-р байр Ганбат багштай 3в баг тус тус эхний 3 байр эзэлж өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Нийслэлийн иргэдийн спортын VIII наадам

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 захирамж дүүргийн засаг даргын 2019 А/250 захирамжийн дагуу зохион байгуулагдсан Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын VII наадам”-ыг 2019 оны 06 сарын 20-с 110 сарын 06-ны хооронд 3 үе шаттайгаар нэгдсэн зааварт заасан 7 спортын төрлөөр зохион байгууллаа.

Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын VIII наадам”-ын анхан шатны тэмцээнд эрэгтэй 5673 эмэгтэй 4609 нийт 10282 иргэн давхардсан тоогоор хамрагдсан бол бүс, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 2094 тамирчин анхан шат буюу дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 12506 иргэн давхардсан тоогоор хамрагдсан байна.

“Иргэдийн спортын VIII наадам”-ыг анхан шат болон дүүрэгт зохион байгуулахад хороодын уялдаа холбоо сайжирч, хороодын биеийн тамир, спортын хамтлагын үйл ажиллагаа эрчимжиж, биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдэн, иргэдийг багийн спортын төрөлд дур сонирхолтой болсон зэрэг ач холбогдолтой байна.

Нийслэлийн 380 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан Иргэдийн спортын 8-р их наадмын шигшээ тэмцээнүүд 2019 оны 10 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Шигшээ тэмцээнд Баянзүрх дүүргээс 130 тамирчин оролцлоо.

Иргэдийн спортын наадмыг хэсэг хороондоо амжилттай зохион байгуулж оролцсон Баянзүрх дүүргийн 16-р хорооны Засаг дарга Ш.Ганчимэг шилдэг хорооны шагнал хүртлээ.

Баянзүрх дүүргийн баг тамирчид шигшээ тэмцээнээс: Спорт явган аялал 1-р байр, Сагсан бөмбөг эрэгтэй 3-р байр, Волейбол эрэгтэй, эмэгтэй 2-р байр, Олс таталт 3-р байр, Ширээний шагай эмэгтэй 2-р байр, Софт волейбол 3-р байр тус тус эзэлсэн амжилттай оролцлоо.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ АЖИЛ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ

Баянзүрх дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2019 оны “Ажил танилцуулах өдөрлөг” арга хэмжээ 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Өдөрлөгийн нээлтэнд Биеийн тамир, спортын хорооны дарга Монгол улсын начин /МУГД/ С.Эрдэнэбат, Нийслэлийн биеийн тамир спортын хорооны мэргэжилтэн Бямбасайхан нар нээж үг хэллээ.

Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд идэвхи санаачлагатай оролцдог, иргэдийн спортын их наадмуудад баг тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулж амжилт үзүүлсэн

тамирчдыг Биеийн тамир спортын газрын “Спортын алдар” медалиар Н.Түмэнжаргал, “Алтан од” медалиар А.Маруся нарыг шагнав.

Шагнал гардуулах ёслолын арга хэмжээний дараа 48-р сургуулийн сурагч Хулан, Марал “Зүгээрл инээмсэглэ”, П.Хэрлэнзаяа “Аягат бүжиг”, Амгалан цогцолбор сургуулийн багш Тамирчны алдар, Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Э.Оргилмаа дасгалжуулагчтай / ОУХМ / Гимастик, Д.Хүдэрбаатар дасгалжуулагчтай / ОУХМ / олимпийн бокс, А.Болд дасгалжуулагчтай / ОУХМ / Тэшүүрийн шигшээ баг, 44 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчид, ЭМТөвийн Б.Сансартуяа багштай хийн дасгал ахмадууд үзүүлэх тоглолт хийж үзүүллээ.

Мөн Биеийн тамир, спортын хорооноос иргэдэд Гир өргөх, дээс тоглох, өдөн бөмбөгийн тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 200 гаруй тамирчид давхардсан тоогоор оролцож эхний 3 байранд шалгарсан тамирчдад өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Тус арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажилласан Биеийн тамир, спортын хорооны дэргэдэх ахмад мастеруудын холбоо, Биеийн тамир, спортын 2018 оны нийслэлийн шилдэг хамтлаг 44 дүгээр сургууль, 48 дугаар сургууль, амгалан цогцолбор сургууль нар хамтран ажиллалаа. Мөн 20 төрлийн гарын авлага бэлтгэн иргэдэд сурталчилан тараалаа.

Ажил танилцуулах өдөрлөгт хүрэлцэн ирсэн биеийн тамир, спортын хорооны хүндэт зочид: Нийслэлийн биеийн тамир спортын хорооны мэргэжилтэн Г.Бямбасайхан, мэргэжилтэн Мөнх-Эрдэнэ, Дэлгэр, Хан-Уул дүүргийн менежер Уранчимэг нар хүрэлцэн ирж үйл ажиллагаатай танилцлаа. Мөн хүүхдийн спортын VI их наадмын тэмцээнийг дүүрэгт 24 төрлөөр зохион байгуулсан бөгөөд эхний 3 байранд шалгарсан сургуулиудыг өргөмжлөлөөр шагнав.





ТАМИРЧДЫН БАЯРЫН ӨДӨРЛӨГ СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ

“Олон улсын олимпийн өдөр”, “Токио олимп сан”-гийн нээлттэй хамтатган тэмдэглэх Тамирчдын баярын хүрээнд олон нийтэд биеийн тамир, спортыг сурталчлан таниулах нийтийн биеийн тамирын арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Арга хэмжээний нээлтэнд оролцогсдод баяр хүргэж Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, БСШУСЯ-ны харьяа Биеийн тамир спортын газрын дарга Шаравжамц болон бусад албаны төлөөлөл хүрэлцэн ирлээ.

Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн гишгээ багийн тамирчид, Ахмад мастеруудыг холбоо, Биеийн тамир спорт хорооны дэргэдэх Спорт явган аялалын Дэвжих клубууд нийт 10 байгууллагын 70 гаруй тамирчид баярын арга хэмжээнд идэвхитэй оролцлоо. Биеийн тамир спортын хорооноос иргэд, хүүхэд, залуучуудад зориулан өдөнбөмбөг, дээсэнд үсрэлтийн тэмцээн зохион байгуулж явууллаа



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН АХМАДЫН СПОРТ ЯВГАН АЯЛАЛЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн ахмадын спорт явган аялалын тэмцээн 2019 оны 06-р сарын 26-27 ны өдрүүдэд Улиастайн гүүрээс – Хар усан тохой чиглэлд амжилттай явагдаж өндөрллөө. Тэмцээнд 8 багийн 50 гаруй тамирчид оролцлоо.

Тэмцээнд :

1-р байр 5-р хороо “Үйзэн” баг

2-р байр 17-р хороо “Баянзүрх” баг

3-р байр 12-р хороо “Жанжин” баг тус тус шалгарлаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН “ИРГЭДИЙН СПОРТЫН VII НААДАМ”-ЫН “СПОРТ ЯВГАН АЯЛАЛ”-ЫН ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 захирамж дүүргийн засаг даргын 2019 А/250 захирамжийн дагуу зохион байгуулагдаж байгаа Баянзүрх дүүргийн “Иргэдийн спортын VII наадам”-ын спорт явган аялалын дүүргийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 09 дүгээр сарын 7-8-ны өдөр Жуковоос Хар-Усан тохой чиглэлд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 4 бүсээс шалгарсан 5 багийн 70 тамирчин өрсөлдсөнөөс :

- 1-р байранд 27-р хороо
- 2-р байранд 4-р хороо
- 3-р байранд 26-р хороо тус тус эзэллээ.

Тэмцээний шүүгчээр спорт явган аялалын мастер Ш.Дүүргиймаа, Цогзолмаа, Чулуунбаатар, О.Түмэнжаргал, С.Сувд, Б.Мөнхзаяа нар ажиллалаа. Хурд, хүч, авхаалж самбаагаараа бусдыгаа тэргүүлэн амжилттай оролцсон Батдэлгэр Засаг даргатай 27-р хорооны баг хамт олон Нийслэлийн иргэдийн Спорт явган аялалын VIII их наадамд Баянзүрх дүүргээ төлөөлөн оролцлоо.



“ЦЭВЭР-АГААР-АВТОМАШИНГҮЙ ӨДӨР” ӨДӨРЛӨГИЙН ТАЙЛАН

“Цэвэр агаар Автомашингүй өдөр” өдөрлөг 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Сүхбаатарын талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Өдөрлөгийн хүрээнд Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хороо иргэдийн дунд гир өргөх, дээсэнд үсрэх, байрнаас уртад харайх гэсэн 3 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулсан. Тэмцээнд нийт 80 гаруй иргэд хамрагдаж төрөл тус бүрд эхний 3 байранд шалгарсан иргэдийг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.



СУРГАЛТ:

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХАРЬЯА ХЭЛТЭС АЛБАДЫН СПОРТ ХАМТЛАГИЙН АРГА ЗҮЙЧ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ СУРГАЛТ

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 9.3.1 дүгээр зүйлийг үндэслэн, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, харьяа хэлтэс албадын ажилтан албан хаагч, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг сургалт семинарт өргөнөөр хамруулах, тэдний идэвхи сонирхолыг дэмжих, ширээний теннисний спортыг түгээн дэргэрүүлэх сурталчилах зорилгоор 2019 оны 3 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Баянзүрх дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэр дэх “Цагаан сүлд” ширээний теннисний холбооны спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө.

Сургалт семинарт 10 сургууль, 5 албан байгууллагын 20 гаруй ажилтан, багш хамрагдаж Ширээний теннисний спортын хөгжлийн түүх, онол, үндсэн заах арга техник зэрэг онол, практик хосолсон сургалтыг хөтөлбөр хуваарь гарган зохион байгууллаа.

Сургалтыг Ц.Баатар /Олон улсын дасгалжуулагч, спортын мастер/
Д.Мөнхбаяр /Дасгалжуулагч, спортын мастер/
Г.Энхболд /Дасгалжуулагч, спортын мастер/ Биеийн тамир спорт хорооны мэргэжилтэн С.Сувд Б.Мөнхзаяа нар удирдан явууллаа. Сургалт семинарт оролцсон албан хаагч, багш нарт гарын авлага, сертификатыг гардуулан өглөө.

СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭН:

✚ 2019 онд спортын уралдаан тэмцээнийг **57** удаа зохион байгуулж **456** байгууллагын **6037** тамирчин хамрагдсан байна.

✚ Баянзүрх дүүргийн тамирчид нэрэмжит болон хот, улсын, олон улсын тэмцээнээс алт-124, мөнгө-124, хүрэл -156 нийт **404** медаль хүртлээ. **Хэрэгжилт 100 %**

ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН:

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН VI НААДМЫН АНХАН ШАТНЫ ТЭМЦЭЭН

Тэшүүрийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Тэшүүр”-ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 02-р сарын 25 ны өдөр Хандгайтын мөсөн гулгуурын талбай дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 10 байгууллагын 96 тамирчин оролцлоо.



Чөлөөт бөхийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам, Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах Чөлөөт бөхийн тэмцээн 2019 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Амгалан цогцолбор

сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд дүүргийн улсын болон хувийн хэвшлийн нийт 13 сургуулийн 150 гаруй өсвөрийн тамирчид 20 жинд авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. Тэмцээний жин тус бүрт аварга болсон тамирчид 2019 оны 09 сарын 10-15 -ний өдрүүдэд болох Монголын хүүхдийн спортын VI наадмын шигшээ тэмцээнд оролцох эрх авлаа.

Тэмцээний багийн дүнгээр:

I байр-Д.Галэрдэнэ багштай Амгалан цогцолбор сургууль 125 оноогоор

II байр- Д.Амгаланбаатар багштай Шавь цогцолбор сургууль 55 оноогоор

III байр -М.Хишигдалай, Б.Буяндалай багштай 87-р сургууль 50 оноогоор тэргүүллээ.



Өсвөр үе, залуучуудын “100-н буудалт даам” –ны аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн өсвөр үе, залуучуудын “100-н буудалт даам” –ны аварга шалгаруулах тэмцээн 03-р сарын 02-ны өдөр Шавь цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 15 сургуулийн 270 хүүхэд оюун ухаанаа сорин өрсөлдлөө. Багийн дүнгээр :

1-р байр Г.Нармандах дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль

2-р байр П. Энхсаруул дасгалжуулагчтай 21-р сургууль

3-р байр Б.Сувдмаа дасгалжуулагчтай Амгалан цогцолбор сургууль тус тус шалгарлаа.



“Жү-до” бөхийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн өсвөр үеийн “ЖҮ-ДО” бөхийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 3-р сарын 09-ны өдөр Амгалан цогцолбор сургууль дээр амжилттай явагдаж өндөрллөө. Тэмцээнд нийт 18 сургуулийн 200 гаруй хүүхэд авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Багийн дүнгээр :

1-р байр М.Одонбаяр дасгалжуулагчтай Амгалан цогцолбор сургууль

2-р байр Д.Амгаланбаатар дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль
3-р байр М.Амаржаргал дасгалжуулагчтай 102-р сургууль тус тус шалгарлаа.



Самбо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн Самбо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03-р сарын 16-нд Амгалан цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 10 багийн 130 гаруй тамирчид авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

БАГИЙН ДҮНГЭЭР

1-р байр 98 оноотой Амгалан цогцолбор сургууль

2-р байр 80 оноотой 102-р сургууль

3-р байр 44 оноотой Шавь цогцолбор сургууль тус тус шалгарлаа.



Таеквондогийн тэмцээн

Энэ удаагийн тэмцээнд Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг арван нэгэн клуб, ЕБС-ууд оролцож Бага нас Б, Бага нас А, Өсвөр нас гэсэн 3 ангилалд нийт 10 байгууллагын 170 гаруй тамирчид өрсөлдсөн томоохон тэмцээн болж өнгөрлөө. Тэмцээний онцлог нь Дэлхийн Таеквондогийн Холбооны онооны цахим системийг ашиглан тоглолтуудыг шүүн явуулсан билээ.



Өсвөр насны ангилалд жин тус бүрд түрүүлсэн тамирчид Хүүхдийн VI их наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхээ авсан юм.

Бага насны Б ангилалд Торнадо кик, Алдар Спорт хороо, Монте роза клубууд багийн дүнгээр эхний 3 бар эзэлж, Бага насны А ангилалд Кёнхи, Алдар спорт хороо, Нэгэн бүл клубууд, Өсвөр насны ангилалд 97-р сургууль, 79-р сургууль, ХСИС-ийн ахлах сургуулиуд тус тус багийн дүнгээр эхний 3 байр эзэлсэн юм. Тэмцээнд түрүүлсэн хүүхдүүд Монголын хүүхдийн спортын наадмд оролцох эрх авлаа.

Боксын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн Боксын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03-р сарын 16-нд Шавь цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 14 сургуулийн 150 гаруй боксчид хурд, хүчээ сорин өрсөлдлөө. **Багийн дүнгээр :**

- 1-р байр Б.Ууганхүү дасгалжуулагчтай 79-р сургууль
- 2-р байр Д.Алтанзул дасгалжуулагчтай 44-р сургууль
- 3-р байр Д.Хүрэлноров дасгалжуулагчтай 97-р сургууль шалгарлаа.



“Шатар”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн өсвөр үеийн Шатар-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 03-р сарын 30 ны өдөр Баянзүрх цогцолбор сургууль дээр амжилттай явагдаж өндөрллөө. Тэмцээнд нийт 39 байгууллагын 510 гаруй тамирчид оролцлоо. Багийн дүнгээр :

- 1-р байр 33-р сургууль
- 2-р байр 84-р сургууль
- 3-р байр Оюунлаг тус тус шалгарлаа.



“Сагсан бөмбөг” -ийн аварга шалгаруулах тэмцээн

Хүүхдийн спортын VI их наадам Баянзүрх дүүргийн “Сагсан бөмбөг”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 08-09 ны өдрүүдэд 33-р сургууль, 48-р сургууль, 87-р сургууль, Шавь цогцолбор сургууль, 120-р сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 17 сургуулийн 33 багийн нийт 396 тамирчин оролцлоо. Шагналт байранд :

Эмэгтэй

1-р байр 79-р сургууль
2-р байр 33-р сургууль
3-р байр 48-р сургууль

Эрэгтэй

1-р байр 48-р сургууль
2-р байр 33-р сургууль
3-р байр 84-р сургууль

Багийн нийлбэр дүнгээр

1-р байр 48-р сургууль
2-р байр 33-р сургууль
3-р байр 79-р сургууль тус тус шалгарлаа.



Хөнгөн атлетикийн аварга шалгаруулах тэмцээн

Хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн Хөнгөн атлетикийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 04-05 ны өдрүүдэд ҮБХИС талбайд амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд нийт 16 сургуулийн 250 гаруй тамирчид хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Багийн дүнгээр :

1-р байр Нэргүйбаатар дасгалжуулагчтай Тэмүүжин өрлөг сургууль
2-р байр Батсанаа дасгалжуулагчтай 102-р сургууль
3-р байр Алтанзул дасгалжуулагчтай 44-р сургууль тус тус шалгарлаа.



”Буудлага” -ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Хүүхдийн спортын VI их наадам Баянзүрх дүүргийн “Буудлага”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 06- ны өдөр Шавь цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 8 сургуулийн 50 гаруй тамирчид оролцлоо. Тэмцээний үйл ажиллагаанд Монгол Улсын Гавьяат Тамирчин, Хөдөлмөрийн Баатар О.Гүндэгмаа, Монгол Улсын Гавьяат Дасгалжуулагч Л.Ундралбат, Монгол Улсын Бригадын Генерал н.Баярмагнай нар хүрэлцэн ирж тэмцээнд оролцож буй өсвөрийн тамирчдад амжилт хүслээ.

Багийн дүнгээр:

1-р байр Амгаланбаатар дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль

2-р байр Төгөлдөр дасгалжуулагчтай Тэмүүжин өрлөг сургууль

3-р байр Одонбаяр дасгалжуулагчтай Амгалан цогцолбор сургууль тус тус шалгарлаа.



3х3 ”сагсан бөмбөг” -ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Хүүхдийн спортын VI их наадам Баянзүрх дүүргийн 3х3 “Сагсан бөмбөг”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 10- ны өдөр 127-р сургууль, дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 14 сургуулийн 26 багийн нийт 104 тамирчин оролцлоо. Шагналт байранд :

Эмэгтэй

1-р байр 53-р сургууль

2-р байр 14-р сургууль

3-р байр 79-р сургууль

Эрэгтэй

1-р байр Амгалан цогцолбор сургууль

2-р байр Төгс дэлгэрэх

3-р байр Шинэ монгол тус тус шалгарлаа.

“Волейбол” -ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Волейбол”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 13-14 ны өдрүүдэд Шавь цогцолбор сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 14 сургуулийн 24 багийн 288 тамирчин оролцлоо. Шагналт байранд :

ЭРЭГТЭЙ

1-р байр Д.Өлзийхутаг дасгалжуулагчтай 21-р сургууль

2-р байр И.Тамир дасгалжуулагчтай 84-р сургууль

3-р байр О.Баттөгөлдөр дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль

ЭМЭГТЭЙ

1-р байр Д.Өлзийхутаг дасгалжуулагчтай 21-р сургууль

2-р байр О.Баттөгөлдөр дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль

3-р байр Ё.Энхбат дасгалжуулагчтай 53-р сургууль тус тус шалгарлаа.



“Ширээний теннисний” өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “ШИРЭЭНИЙ ТЕННИС” – ний өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 4-р сарын 13-нд “Цагаан сүлд”- Ширээний теннисны клуб дээр амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 15 байгууллагын 64 тамирчин авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Багийн дүнгээр

1-р байр 44-р сургууль

2-р байр СОС хотхон

3-р байр Билгүүн номч тус тус шалгарлаа.



“Хүндийн өргөлт” -ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Хүндийн өргөлт”-ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 20 ны өдрүүдэд Алдар спорт хорооны зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 8 сургуулийн 220 тамирчин оролцлоо. Багийн дүнгээр :

1-р байр Д.Амгаланбаатар дасгалжуулагчтай Шавь цогцолбор сургууль

2-р байр М.Одонбаяр дасгалжуулагчтай Амгалан цогцолбор сургууль

3-р байр Д.Эрдэнэбаяр дасгалжуулагчтай 53-р сургууль тус тус шалгарлаа.



“Байт харваа” -ны өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Хүндийн өргөлт”-ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 20 ны өдрүүдэд Алдар спорт хорооны зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 7 сургуулийн 70 гаруй тамирчид оролцлоо.

Багийн дүнгээр :

1-р байр 33-р сургууль

2-р байр English school of Mongolia

3-р байр 14-р сургууль тус тус шалгарлаа.



Спортын гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн аварга шалгаруулах Спортын гимнастикийн тэмцээн 2019 оны 04-р сарын 27 – ны өдөр Монголын гимнастикийн холбооны гимнастикийн төв зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд Монголын гимнастикийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Г.Ерөөлбат хүрэлцэн ирж нээн үг хэлж тамирчидад амжилт хүслээ. Тэмцээнд эрэгтэй ганцаарчилсан төрөлд 20, эмэгтэй ганцаарчилсан төрөлд 26, багийн төрөлд 6 багийн 36, нийт 82 тамирчид ур чадвараа сорин өрсөлдөө.



Ганцаарчилсан эрэгтэй төрөлд чөлөөт хөдөлгөөн, бариултай морь, цагаригт дүүжин, харайлт, суга савлуур, турник гэсэн 6 хэрэглэлээр өрсөлдсөн бол эмэгтэй тамирчид харайлт, өндөр нам савлуур, дамжуурга, чөлөөт хөдөлгөөн гэсэн 4 хэрэглэлээр өрсөлдөж шагналт байрт шалгарав.

Байгууллагын нийлбэр дүнгээр :

1-р байр 21-р сургууль

2-р байр 48-р сургууль

3-р байр “Глобал” сургууль тус тус шалгарлаа.

“Футзал” –ны аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Волейбол”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 05-р сарын 11 ны өдөр 14-р сургууль дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 14 сургуулийн 14 багийн 170 тамирчин оролцлоо. Шагналт байранд :

1-р байр 14-р сургууль

2-р байр Шавь цогцолбор сургууль

3-р байр Шинэ монгол сургууль тус тус шалгарлаа.



“Спорт явган аялал” –ын аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Спорт явган аялал”-ын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 05-р сарын 04- ны өдөр Жуковаас – Хар усан тохой чиглэлд амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 8 сургуулийн 11 багийн 80 тамирчин оролцлоо. Шагналт байранд :

1-р байр Шавь цогцолбор сургуулийн 2-р баг

2-р байр 88-р сургууль

3-р байр Шавь цогцолбор сургуулийн 1-р баг тус тус шалгарлаа.



“Крикет” –ийн аварга шалгаруулах тэмцээн

Монголын хүүхийн спортын VI наадам Баянзүрх дүүргийн “Крикет”-ийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 05-р сарын 11-12 ны өдөрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн Крикетийн талбай дээр амжилттай зохион байгуулагдаж өндөрллөө. Тэмцээнд 10 сургуулийн 120 тамирчин оролцлоо.

Шагналт байранд :

1-р байр 120-р сургууль

2-р байр 87-р сургууль

3-р байр Тэмүүжин өрлөг сургууль тус тус шалгарлаа.



Спорт бүжгийн аварга шалгаруулах тэмцээн

Баянзүрх Дүүргийн Бүжгийн спортын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр 53 дугаар сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд Баянзүрх дүүргийн 13 сургуулийн 150 гаруй тамирчид 14 төрлийн хосын болон хамтлаг бүжгийн төрлөөр өрсөлдөж дүүргийн аваргуудаа шалгарууллаа.

Тэмцээний нийлбэр дүнгээр: 1-р байр Шинэ Монгол
2-р байр 84 дүгээр сургууль
3-р байр 44 дүгээр сургууль тус тус эзэлж өргөмжлөл

медалиар шагнаж урамшууллаа.

Тэмцээнийг Монголын бүжгийн спортын холбоо болон Мүүн дансе клубтай хамтран зохион явууллаа.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ӨСВӨР ҮЕИЙН ҮНДЭСНИЙ БӨХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Баянзүрх дүүргийн өсвөр үеийн үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 10-р сарын 02 -нд Шавь цогцолбор сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тэмцээнд нийт өсвөрийн 54 бөх өрсөлдлөө. Шагналт байранд :

16 нас

- 1-р байр Батбөх АЦС
- 2-р байр Рэнцэнжүгдэр 133-р сургууль
- 3-р байр адъяабаатар ШЦС
- 4-р байр Өлзий-отгон АЦС

17 нас

- 1-р байр Батманлай 102-р сургууль
- 2-р байр Нямжав ШЦС
- 3-р байр Алтансүх 92-р сургууль
- 4-р байр Хэрлэнбаатар 102-р сургууль

18 нас

- 1-р байр О.Ихбаяр 120-р сургууль
- 2-р байр Б.Итгэлмөнх Эм ай ю
- 3-р байр н.Нагерренчин
- 4-р байр Х.Энхбат ШЦС



“Начин –Шонхор” Хүүхдийн үндэсний бөхийн барилдаан

2019 оны 03 сарын 31-ний өдөр Баянзүрх дүүргийн биеийн тамир спортын хороо, Алдартан клуб, Монголын Үндэсний бөхийн холбоотой хамтран "Начин шонхор" хүүхдийн үндэсний бөхийн барилдаан зохион байгууллаа. Үндэсний бөхийн харьшгүй хүчит аваргуудын нэрэмжит болгон зохион байгуулаж Ардын засгийн анхны аварга, Сайн ноён Хан аймгийн Лу гүний хошуу буюу Одоогийн Архангай аймгийн Батцэнгэл сумын харъяат Галсанхүүгийн Вандан аваргын нэрэмжит болгон зохион байгууллаа. Тус барилдаанд 6-7 насанд 47 бөх, 8-9 насанд 64 бөх оролцон тойргын журмаар барилдуулан аваргуудаа тодрууллаа:

Уран ГАРАА Дэвээт бөхөөр Г Маргад-Эрдэнэ
УРАН барилдаант бөхөөр Ц.Билгүүн-Эрдэнэ
Ирээдүйтэй бөхийн шагналыг Д .Далайцэрэн тус тус хүртлээ.

